



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 18 өдөр

Дугаар 7/036

Булган сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Биеийн тамир, спортын газрын “А” заланд зориулалтын резинэн шал авахад шаардагдах 15,000,000 (арван таван сая) төгрөгийг Биеийн тамир, спортын газарт шилжүүлэн олгосугай.

2.Шаардагдах зардлыг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  БАРИУН-ЭРДЭНЭ

6324010868